



УРИЛГА

Азийн Хөгжлийн Банк (цаашид “АХБ” гэх)-ны буцалтгүй тусламжаар Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-MON төсөл Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хэрэгжиж байна.

Тус төслийн хүрээнд дэвшилтэт технологийн өвлийн хүлэмжний үндэсний мэргэжилтэнг сонгон шалгаруулахаар зарлаж байна.

Өргөдөл гаргагч нь хүнсний ногооны тариалалт, эсвэл хамгаалагдсан орчинд тариалалт хийх чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн магистраас дээш зэрэгтэй, агрономич мэргэжилтэй эсвэл дэвшилтэт технологит хүлэмжийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, төрийн болон хувийн хэвшлийн салбарт 5-аас дээш жил орчин үеийн дэвшилтэт технологит хүлэмжийн чиглэлээр ажилласан туршлагатай байна.

Мөн АХБ, Дэлхийн банк, НҮБ болон олон улсын бусад байгууллагад хүлэмжийн чиглэлийн төслүүдэд 1-ээс доошгүй жил ажиллаж байсан бол давуу тал болно.

Компьютерын мэдлэг чадвартай байх мөн Англи хэлээр чөлөөтэй ярих, бичих чадвартай байна.

Ажил горилогч нь 2020 оны 4-р сарын 26-ны өдрөөс өмнө доорх линкээр орж бүртгүүлнэ үү.

АХБ-ны форматаар дэлгэрэнгүй CV-гээ монгол, англи хэлээр бичиж АХБ-ны сайтанд зааврын дагуу байршуулна уу.

https://selfservice.adb.org/OA_HTML/OA.jsp?OAFunc=XXCRS_CSRN_PROFILE_PAGE&csrnrnKey=CE56FEFCF55340E2C7B74553CE8973A1B767292010F3A4BD4732387D56ABB386&fromDER=Y&refresh_csrn=true

Хүлээн авах эцсийн огноо: 2020 оны 4-р сарын 26-ны өдөр.